

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны 35 дугаар тэмдэглэлд:

XX.1. Салбаруудын хүрээнд хэрэгжүүлж байгаа өвөлжилтийн бэлтгэл ажлын явцын тухай мэдээллийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан,

1. Төв суурин газрын 2017 оны өвөлжилтийн бэлтгэл хангах талаар хэрэгжүүлж байгаа ажлаа эрчимжүүлж ажиллахыг холбогдох сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.

2. Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл хангах зарим ажил, арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг Сангийн яамтай хамтран судлахыг холбогдох сайд нарт, эхний ээлжинд шаардлагатай нэмэлт зардлыг Хөгжлийн банк болон арилжааны банкуудтай хамтран ажиллаж холбогдох байгууллага, аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэхийг Сангийн сайд Б.Чойжилсүрэнд тус тус даалгав.

3. “2017-2018 оны өвөлжилт, хаваржилтыг хүндрэл, бэрхшээлгүй даван туулах бэлтгэл хангахтай холбогдуулан ОХУ болон хөрш зэргэлдээ улс орнуудаас өвс, тэжээл, тосны ургамал болон гурил, малын тэжээл үйлдвэрлэх зориулалтаар үр тариа импортоор оруулах, 2018 онд шаардагдах улаан буудайн үрийг дотоодын аж ахуйн нэгжүүдээс худалдан авч нөөцлөх, уг зориулалтаар гадаад, дотоодын зээл, тусламж авах талаар гэрээ хэлэлцээр хийх, зохих зохицуулалт, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэнд даалгав.

4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд ургац хураалт, мал өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, байгаль цаг уурын болзошгүй хүндрэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг батлан, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах, хадлан, ногоон тэжээл болон бусад тэжээл бэлтгэх, худалдан авч нөөц бүрдүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.


5. Улсын тусгай хамгаалалттай газар нутаг, хилийн зурвас бүс нутагт малчид хадлан бэлтгэх, малчид өвөлжиж, хаваржих зөвшөөрөл олгохыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Хил хамгаалах ерөнхий газрын дарга Ц.Сэргэлэн нарт даалгав.

6. Өвөлжилт хүндэрсэн үед малын гоц халдварт өвчин гаргахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор эдгээр өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг дулааны улиралд сайтар зохион байгуулж, газар дээр нь хяналт тавьж ажиллах, мал нь өвчилсөн малчид малаа эрүүл байлгахгаар хуулиар хүлээсэн

үүргээ биелүүлсэн эсэхийг шалгах, урьдчилан сэргийлэх болон эрүүлжүүлэх арга хэмжээнд малаа хамруулаагүй малчдад хариуцлага тооцож ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэнд хариуцуулав.

7. Хөдөө аж ахуйн салбарын болон төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг эрчимжүүлэх асуудлаар аймаг, нийслэлийн Засаг дарга нарын семинар, ярилцлагыг 2017 оны 8 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулахаар тогтож, тухайн аймгийн өвөлжилтийн бэлтгэл хангах асуудлыг Засгийн газрын гишүүдэд хариуцуулж, орон нутагт ажиллуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбатад даалгаж, өвөлжилтийн бэлтгэл хангах төлөвлөгөө, түүний хэрэгжилт, отроор өвөлжих малыг аймаг болон сум хооронд зохицуулах болон сургууль, цэцэрлэг, эмнэлэг, цахилгаан, шугам сүлжээ, халаалт, нийтийн аж ахуйн байгууллагын засвар үйлчилгээ зэрэг асуудлаар аймаг, нийслэлийн Засаг дарга нартай нэг бүрчлэн ярилцаж, хамтарсан төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж ажиллахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгав.

8. Бүх шатны сургууль, цэцэрлэгийн барилгын засварын ажлыг 9 дүгээр сарын 1-ний дотор дуусгах арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Г.Чулуунбаатарт, эрчим хүчний тоног төхөөрөмжийн шинэчлэл, засвар үйлчилгээний ажлыг графикт хугацаанд нь дуусгаж, цахилгаан, дулааны доголдол гаргахгүй ажиллахыг Эрчим хүчний сайд П.Ганхүүд тус тус даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР